

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ХЭРЭГЖИЖ БАЙГАА ДЭД ХӨТӨЛБӨРҮҮДИЙН 2021 ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

2022.02.10

Дархан-Уул

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор батлагдсан, “Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан аймгийн дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, гүйцэтгэлийг тавьсан зорилт, хүрэх түвшинтэй нь харьцуулан хэрэгжилтийн түвшинг тогтоон үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулж, зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй:

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасны дагуу Төрийн захиргаа удирдлагын хэлтсээс нэгтгэж ирүүлсэн Дархан-Уул аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс баталсан дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

Үнэлгээний дүгнэлт:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор батлагдсан 12 дэд хөтөлбөрийн 276 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд **95.50% буюу 4.78 онооны** үнэлгээтэй байна.

МУЗГ-ын 2021 оны 10-р сарын 13 өдрийн 314-р тогтоолоор “Эрчим хүчийг хэмнэх” дэд хөтөлбөр хүчингүй болж “Мал, амьтны эрүүл мэнд” дэд хөтөлбөрийн хэрэгжих хугацаа 2021 оноор дуусгавар болж байна.

2022 онд хэрэгжих хугацаа дуусах 1, 2023 онд хэрэгжих хугацаа дуусах 1, 2024 онд хэрэгжих хугацаа дуусах 10, 2026 онд хэрэгжих хугацаа дуусах 1 нийт 14 хөтөлбөр үргэлжлэн хэрэгжиж байна. Үүнээс Эрүүл Дарханчууд (2017-2021; 2022-2026), Тохилог орчин-Эко хороолол (2017-2020; 2020-2024), Эрчимжсэн мал аж ахуйг дэмжих (2019-2020; 2021-2023) хөтөлбөрүүд 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр батлагдсан байна.

Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд хөрөнгө санхүүжилтийг тодорхой тусгаагүй, хөрөнгийн эх үүсвэр нь тодорхойгүй, цаг үеийн асуудлаас шалтгаалсан олон нийтийн хүрээнд хийгдэх сургалт, арга хэмжээнүүдийн хэрэгжилт удаашралтай хангалтгүй байна.

Үнэлгээг хүснэгтээр үзүүлбэл:

#	Хөтөлбөрийн нэр	Арга хэмжээ	Үүний дотор /арга хэмжээ тоо/						Хэрэгжилтийн хувь
			100%	Тодорхой үр дүнд хүрсэн		Эрчимжүүлэх шаардлагатай		0%	
				90%	70%	50%	30%		
1	Атар-IV дэд хөтөлбөр	6	5	1	-	-	-	-	98.33%
2	Оюунлаг Дарханчууд дэд хөтөлбөр	19	10	3	1	5	-	-	83.68%
3	Утаагүй Дархан дэд хөтөлбөр	3	3	-	-	-	-	-	100%
4	Халамжаас хөдөлмөрт дэд хөтөлбөр	17	14	2	-	-	1	-	94.71%
5	Цэвэр хот дэд хөтөлбөр	11	10	1	-	-	-	-	99.09%
6	Шарилжгүй Дархан дэд хөтөлбөр	15	13	-	1	-	1	-	93.33%
7	Тохилог орчин-Эко хороолол	16	12	3	1	-	-	-	96.25%
8	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр	19	15	1	-	3	-	-	91.58%
9	Мал, амьтны эрүүл мэнд дэд хөтөлбөр	29	22	5	2	-	-	-	96.21%
10	Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих дэд хөтөлбөр	30	20	9	1	-	-	-	96%
11	“Хүний хөгжил”	6	6	-	-	-	-	-	100%
12	“Эрүүл Дарханчууд”	171	81	20	3	1	-	-	96.76%
НИЙТ ДҮН		276	211	45	9	9	2	-	95.50%

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС